**МОНГОЛ УЛС**
**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 05 сарын 08 өдөр　　　　Дугаар А/291　　　　Ховд

Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь заалтуудыг үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2006 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Тахилт багийн 5-31 тоот 1500м2 хэмжээтэй, 3750000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Чимидийн Даваасүрэнд үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2.Дээрх нэр бүхий иргэдэд шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Б.Баярсүх/, Улсын бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /С.Хоролсүрэн/ нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 96 дугаар захирамжийн 15,17,18,19 дэх заалтанд холбогдох хэсгийг тус тус хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА　　　　Б.ДҮГЭРЖАВ

Zax A/291 Ch
02 01434

Аймгийн Засаг даргын 2019 оны
5 дугаар сарын 08-ны өдрийн А/291дүгээр
захирамжийн хавсралт

## ГЭР БҮЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ

| Овог нэр | Хаяг | Газрын хэмжээ /м2/ | Газар өмчилж авсан захирамжийн огноо | Дугаар | Хавсралтанд орсон дугаар |
|---|---|---|---|---|---|
| Чимид Даваасүрэн | Тахилт баг 5-31 тоот | 1500 | 2006-05-18 | 96 | 15-19 |

-оОо-